



## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 1/1422

Улаанбаатар хот

### Түргэн үйлчилгээний цэгийн /ТҮЦ/ машиныг ашиглах журам батлах тухай

МУИС-ийн дүрмийн 4.5.1, 7.3 дахь хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 1.8, 2.1.3, 2.1.4 дэх заалт, Захиргааны зөвлөлийн 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУИС-ийн оюутан суралцагчид тодорхойлолт олгох зориулалттай Түргэн үйлчилгээний цэг /ТҮЦ/-ийн машиныг ашиглах журмыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалтын нэгдсэн алба /Ч.Ундрал/, Мэдээллийн технологийн алба /А.Баатарбилэг/-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Д-р.А.ГАЛТБАЯР

Захирлын 2014 оны 12 дугаар сарын 16  
өдрийн... тушаалын хавсралт



## МУИС-д ТҮЦ машиныг ашиглах журам

### 1. Журмын зорилго:

- 1.1. МУИС-ийн оюутан суралцагч Түргэн үйлчилгээний цэгийн машинаас (цаашид ТҮЦ гэнэ) тодорхойлолт авах үйл явц, ТҮЦ-ийн засвар үйлчилгээ, хэвийн ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, төлбөр тооцоо хийх, талуудын хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлох зэрэг харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино

### 2. ТҮЦ-ийн тусламжтайгаар авах үйлчилгээний төрөл, түүнийг батлах горим

- 2.1. Оюутан суралцагч тодорхойлолт лавлагаа зэрэг үйлчилгээ авахдаа оюутны үнэмлэх, СиСи мэдээллийн системд нэвтрэх нууц үгээ ашиглан ТҮЦ машинаар үйлчлүүлнэ.
- 2.2. Оюутны тодорхойлолт, Дүнгийн тодорхойлолт нь МУИС-ийн лого, холбогдох мэдээлэл бүхий А4 -ийн хэмжээтэй цаасан дээр хэвлэгдэх бөгөөд Сургалтын нэгдсэн албаны даргын гарын үсэг, албаны тэмдэгтэй байна. Хэвлэх цаас нь Монгол улсын үнэт цаас байж болно.
- 2.3. Оюутны болон дүнгийн тодорхойлолт нь Монгол, Англи хэлээр байх бөгөөд оюутан сонгох боломжтой байна. Тодорхойлолт нь хичээлийн жилийн олгосон тухайн улиралдаа хүчинтэй.
- 2.4. Дүнгийн тодорхойлолт болон голч дүн Сургалтын журмын холбогдох зүйл заалтаар зохицуулагдана
- 2.5. Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнээс хамаарч шинэ болон бусад нэмэлт үйлчилгээг ТҮЦ-ээр үзүүлж болох бөгөөд эдгээр үйлчилгээний төрөл хэлбэр, тэдгээрт тавих шаардлагыг холбогдох алба хэлтсээс санал болгож, Мэдээллийн технологийн албатай зөвшилцсөний дагуу МУИС-ийн захиргааны зөвлөлөөр хэлэлцэж МУИС-ийн захирлын тушаалаар батална.

### 3. ТҮЦ машинаар авах үйлчилгээний хураамж

- 3.1. Суралцагч нь тухайн хичээлийн жилд оюутны болон дүнгийн тодорхойлолтыг тус бүрээс 2 удаа үнэ төлбөргүй авах ба үүнээс дээш тоогоор авах тохиолдолд тухай бүр 500 төгрөгийн хураамж төлнө.
- 3.2. Хураамжийг суралцагч өөрийн СиСи дансыг ашиглан бэлэн бусаар болон машинд 500 -ийн мөнгөн дэвсгэрт хийж бэлнээр төлж болно.

#### 4. ТҮЦ-ийн байршил, ашиглалт

- 4.1. ТҮЦ машиныг МУИС-ийн хичээлийн байр болон оюутны дотуур байранд, шаардлагатай техник технологи, аюулгүй ажиллагааны нөхцлийг сайтар хангасан, суралцагч чөлөөтэй нэвтрэх боломж бүхий орчинд байршуулна.
- 4.2. ТҮЦ машиныг ашиглах зааврыг товч ойлгомжтой хэлбэрээр бичиж байрлуулсан байна.
- 4.3. ТҮЦ-ийн программ хангамж, техникийн засвар үйлчилгээ болон мэдээллийн аюулгүй байдлыг Мэдээлэл тенологийн алба хариуцна. ТҮЦ машиныг ашиглахтай холбоотой зааврыг боловсруулж хэрэглэгчдийг мэдээллээр хангана.
- 4.4. ТҮЦ-ийн хор, цаасны хангамжийг сургуулийн Сургалтын нэгдсэн алба зохион байгуулна. Сургалтын алба болон Санхүүгийн алба нь ТҮЦ машины орлогыг машинаас авч, сургуулийн дансанд шилжүүлэх бөгөөд санхүүгийн холбогдох дүрэм журмыг чанд мөрдөн ажиллана.
- 4.5. ТҮЦ-ийн эд хариуцагч нь тухайн байрны зохион байгуулагч байх бөгөөд хамгаалалтын албаны хамт бүрэн бүтэн байдалд хяналт тавьж хариуцлага хүлээж ажиллана.

#### 5. Бусад зүйл

- 5.1. Суралцагч нь ТҮЦ машиныг, заавар журмын дагуу ашиглах ба буруутай ажиллагаанаас учирсан хохирлыг барагдуулна.
- 5.2. Талууд ТҮЦ машинд гарсан аливаа эвдрэл, саатлын талаар тухайн байрны зохион байгуулагч болон сургалтын албанд мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг авахуулах үүрэг хүлээнэ.